# ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ ТӨХК-ИЙН АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Зорилго | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур | Биелэлт |
|---|---|---|---|---|
| 1 | Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх | 1.1.Авлигатай тэмцэх газраас соён гэгээрүүлэх чиглэлээр бэлтгэсэн контентуудыг а/байгууллагын албан ёсны цахим хуудас; б/сошиал сувгууд; в/дотоод сүлжээ; г/хэвлэл мэдээллийг хэрэгсэл, д/мэдээлэл сурталчилгаа самбар, лед дэлгэц, е/бусад (салбар байгууллагууд) хэлбэрээр сурталчилж, олон нийтэд хүргэх | -Баримтжуулсан байх<br>-Үр дүнг тооцож, тайлагнасан байх. (түгээсэн тоо, давтамж, авсан хандалтын тоо)<br>-Харьяа газар, нэгжүүдийг хамруулсан байх. | Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн контентуудыг компанийн албан ёсны цахим хуудас болох https://transco.mn/news/ сайт болон фэйсбүүк хуудаст тухай бүр байршуулж түгээж ажилласан. Авлигын эсрэг суртачилгааны материалыг компанийн хэлтэс, салбар, албанд тус бүр хүргүүлж нийт 500 гаруй материалыг тараасан. Мөн албан конторуудын мэдээллийн самбарт зурагт хуудсуудыг байршуулан олон нийт болон компанийн ажилтнуудийг мэдээлэлтэй танилцах боломжоор хангаж ажилласан.<br>    |
| | | 1.2.Өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан иргэд, олон нийтэд чиглэсэн соён гэгээрүүлэх нээлттэй хаалганы өдөрлөг, арга хэмжээг зохион байгуулах | -2-оос доошгүй өдөрлөг, нөлөөллийн үйл ажиллагаа г.м соён гэгээрүүлэх арга хэмжээг зохион байгуулсан байх;<br>-Үр дүнг тооцож, нотломжийг хавсаргасан байх. | Аймгийн Засаг даргын тамгын газраас зохион байгуулсан Говийн өнгө-Говийн залуус нээлттэй хаалганы өдөрлөг дээр өөрийн компанийн бүтэц, үйл ажиллагааны онцлогийг олон нийтэд ил тод мэдээлсэн.<br> <br>Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах, мөн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Багануур дүүргийн шүүхийн тамгын газраас албан хэрэгцээндээ ашиглах чиглэлээр бэлтгэж ирүүлсэн “Зөрчлийн тухай ойлголт, зөрчигдсөн эрхээ хэрхэн сэргээлгэх талаар” сургалтын гарын авлага хэрэглэгдэхүүнийг “ЗӨБС СУРГАЛТ” телеграм болон “ЭЙБЛ СИСТЕМ”-д төлөвлөгөөний дагуу байршуулж байгууллагын ажилтнуудад мэдээ, мэдээлэл хүргэх ажлыг зохион байгуулан ажилласан. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | 1.3.Өөрийн байгууллагын эрх хэмжээ, үйл ажиллагаатай холбогдуулан эрхлэн гаргадаг ном гарын авлага, сэтгүүл, иргэдэд тараадаг хэвлэмэл материал, зэрэгт авлигын хор хөнөөлийг иргэдэд ойлгуулах, шугэл үлээхийг сурталчлан таниулсан, түүнд уриалсан мэдээлэл болон авлигын мэдээлэх 110 дугаарыг оруулан сурталчлах; | -АТГ-ын авлигын мэдээлэл хүлээн авах дугаарыг төрөл бүрийн хэлбэрээр сурталчлан ажилласан байх;<br>-Тайланд 110 дугаарыг сурталчилсан баримт бүрийн нотломжийг хавсаргасан байх. | Авлигын эсрэг хамтдаа" мэдээллийн самбарт Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, авлигын эсрэг ерөнхий төлөвлөгөө бусад холбогдох мэдээ, мэдээллийг байршуулж, тухай бүр шинэчлэн ажилтнуудад мэдээлэл хүргэн ажиллаж байна. Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн сурталчилгааны материалыг компани болон салбаруудын оффис хүлээлгийн өрөө, мэдээллийн самбар, цаг бүртгэлийн төхөөрөмжийн хажууд тогтмол байршуулан ажиллаж байна.<br><br><br><br> |
| 2 | Ил тод байдлыг сайжруулах, хүнд суртал, чирэгдлийн бууруулах, олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх | 2.1."Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам"-ыг хэрэгжүүлэх; | -Журмыг нийт албан хаагчдад танилцуулах нөлөөллийн ажлыг 2-оос доошгүй удаа зохион байгуулсан байх; | Журмыг компанийн дотоод сүлжээ болох Able программын олон нийтэд бүх ажилтнууд харах, танилцах боломжтойгоор байршуулан ажилласан<br><br><br>Байгууллагын дотоод сүлжээ болох www.able.mn –г өдөр тутмын үйл ажиллагаандаа байнга ашигладаг. Компанийн цахим хуудасны Ил тод байдал болон Хууль эрх зүй цэсэнд компанийн үйл ажиллагаанд |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | мөрдөж байгаа хууль, тогтоомж, дүрэм журам, зааврыг тухай бүр байршуулдаг. |
| | | 2.2. Байгууллагуудын үйл ажиллагаа, үйлчилгээний хүнд суртал чирэгдэлтэй холбоотой ирүүлсэн гомдол, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үр дүнд суурилсан арга хэмжээг хэрэгжүүлж хэвших; | -Шинээр томилогдсон албан хаагчдыг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, ёс зүйн сургалтад бүрэн хамруулсан байх;<br>-Тайланд нотломжийг хавсаргасан байх.<br>-Ирүүлсэн гомдолд хийсэн дүн шинжилгээний үр дүнд суурилсан зэрэг нөлөөллийн арга хэмжээг 2-оос доошгүй удаа зохион байгуулсан байх; | Компанид шинээр томилогдсон ажилтнуудад,<br>Компанийн хэмжээнд төв удирдлага, салбар ёс зүйн хороонууд ажиллаж байгаа бөгөөд ажилтнуудаас гарсан гомдол саналыг хүлээн авч, компанийн ёс зүй дүрэм, ёс зүйн хорооны ажиллах журмын хүрээнд асуудлыг шийдвэрлэж байна. Гарсан гомдол, зөрчлийн мөрөөр нийт ажилтнуудад сэрэмжлүүлэх мэдээ даалгавар, албан даалгавруud өгөгдөн биелэлтийг гарган ажиллаж байна.<br><br>Шинээр томилогдсон албан тушаалтнууд; |
| 3 | | 3.1. Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр тухайн байгууллагаас цахимаар иргэд, олон нийтэд үзүүлж буй цахим үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх чиглэлээр арга хэмжээг зохион байгуулах; | -Цахим үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр 2-оос доошгүй нөлөөллийн ажил зохион байгуулсан байх;<br>-Иргэдэд цахим хэрэглээг таниулж үйлчилгээг түргэн шуурхай авах нөхцөл боломжийг бүрдүүлсэн байх;<br>-Нотломжийг тайланд хавсаргасан байх;<br>- | Ухаалаг сүлжээ болгох чиглэлээр SCADA систем ашиглан<br>3G, 4G хэрэглэгч – 32 дэд станц = Үндсэн сүлжээ болон Технологийн сүлжээ үүсгэх нөхцөл бүрдсэн. ДҮТ ТӨХХК болон УБЦТС ТӨХК-тэй интеграци хийн мэдээллээ солилцох боломжтой болсон.<br> <br>Төрийн үйлчилгээг нээлттэй ил тод байлгах үүднээс https://soe.gov.mn/ сайтад Төрийн өмчит хуулийн этгээдийн нээлттэй мэдээллүүдийг тогтмол оруулж хэвшиж иргэд олно нийтэд танилцах боломжоор хангаж ажилласан. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах | | |    |
| | | 3.2.Байгууллагын дотоод хяналтын механизмыг сайжруулж, албан хаагчдыг авлига, ашиг сонирхлоос ангид байхад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх; | -Албан хаагчдын дунд авлигаа ангид байхад чиглэсэн нөлөөллийн 2-оос доошгүй үр дүнтэй ажил зохион байгуулсан байх;<br>-Байгууллагын алба хаагчид авлигын гэмт хэрэгт холбогдоогүй байх; | Компанийн хэмжээнд Тендер зарлаж өндөр үнээр байгуулж байгаа бүх гэрээнд авлига, ашиг сонирхлоос сэргийлэхийн тулд гарын үсэг зурсан ажилтнууд дахин баталгаажуулж мэдэгдлийг гаргуулан АТГ-ын цахим сайтад мэдээллийг оруулж байна.<br><br>2024 онд компанийн албан тушаалтнууд болон ажилтнууд авлигын гэмт хэрэгт холбогдоогүй болно. |
| | | 3.3.Тухайн байгууллага өөрийн үйл ажиллагааны онцлогт тохируулан авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр шинээр санал, санаачилга гарган тодорхой арга хэмжээг хэрэгжүүлэх; | - Байгууллагын үйл ажиллагаа, үзүүлж буй төрийн үйлчилгээний онцлогт тохируулан зохион байгуулсан арга хэмжээний үр дүнг олон нийтэд мэдээлсэн байх; | 2024.12.24-ний өдөр салбарын 136 ажилтанд танхимаар, цахимаар 140 ажилтан сургалтаар нийт 276 ажилтанд эрүүгийн цагдаагийн кибер гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн ахмад л.Эрхэмбаяр, мөрдөгч Мөнхнаран нараар цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон авлигын гэмт хэргийн талаар сургалт заалгасан.<br>Хөдөлмөрийн тухай хууль, ажилтан албан тушаалтнууд үйл ажиллагаа явуулахад учирч болох эрсдэл түүнээс урьдчилан сэргийлэх болон авлигын гэмт хэргийн талаар ойлголт, цахим орчинд үйлдэгдэж буй залилах, мөнгө угаах, мөрийтэй тоглоом зохион байгуулах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт авсан. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | -Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн зөвлөмж, албан бичгийн хэрэгжилтийг хангасан байх; | <br>Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн зөвлөмж, шийдвэр, албан бичгийн хэрэгжилтийг хэлтэс, салбаруудад хүргүүлэн, мэдээллийн самбар, дотоод сүлжээгээр олон нийтэд танилцуулсан. Компанийн авлигын эсрэг ерөнхий төлөвлөгөөг гүйцэтгэх захирлын 2024 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн А/105 дугаар тушаалаар баталж хэрэгжилтийг хангаж, биелэлтийг хугацаанд нь гарган ажиллаж байна. Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан сургалт, Авлигын эсрэг үндэсний чуулганд салбар, нэгжүүдийн ажилтнуудыг цахимаар хамрагдах нөхцөлийг бүрдүүлж ажилласан.<br><br>2024 онд албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн ажилтнуудын хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг АТГ-т хүргүүлэн хянуулсан байна. Компанийн хөрөнгө, орлогын болон хувийн ашиг сонирхлын мэдүүлэг гаргах үүрэг бүхий ажил, албан тушаал, ажилтны нэрсийн жагсаалтыг жил бүр шинэчлэн шаардлагатай зарим албан тушаалыг нэмэх саналыг Эрчим хүчний яаманд хүргүүлж, жагсаалтыг гүйцэтгэх захирлын тушаалаар шинэчлэн батлуулж мөрдөн ажиллаж байна. 2024 онд ХАСХОМ-ын мэдүүлэг гаргах үүрэг бүхий ажилтнуудаас мэдүүлгийг хуулийн хугацаанд 100 хувь гаргуулан, АТГ-ын цахим программд баталгаажуулсны зэрэгцээ, баталгааны маягтыг хүлээн авч үртгэн гарын үсэг зуруулж баталгаажуулсан болно. ХАСХОМ-ын мэдүүлэг гаргуулж, баталгаажуулах ажлыг хугацаанд нь гаргуулсан, ямар нэгэн зөрчил гараагүй болно |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | 3.3.1. Гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн ил тод байдлыг хангах, АТГ төслийн нэгжүүдэд авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр хамтран ажиллахад дэмжлэг үзүүлэх; | -Төсөл, хөтөлбөрийн мэдээллүүд ил тод болсон байна; - Томоохон төсөл, хөтөлбөрийн нэгжүүдтэй уулзалт зохион байгуулсан байх, | Тус компани дээр ХБНГУ-ын Сэргээн босголт, зээлийн банк (KFW)-ны 20.45 сая еврогийн санхүүжилтэй ”Төвийн бүсийн цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний үр ашгийг дээшлүүлэх төсөл” хэрэгжиж байна. Төслийн танилцуулга, явцын талаархи мэдээллийг ЭХЯ, СЯ, ЦДҮС ТӨХК-ийн цахим хуудсууд дээр байршуулсан бөгөөд олон нийтэд нээлттэй байдаг. Төсөл хэрэгжүүлэх нэгжийн зүгээс хуулийн дагуу Шилэн дансанд тухай бүр мэдээлэл байршуулдаг. Эрчим хүчний дэд сайдын зүгээс зохион байгуулдаг шуурхайд сууж, салбарт хэрэгжиж буй бусад төслүүдийн хамт хэрэгжилтийн тайлан мэдээллийг 7 хоног бүр хүргүүлэн, мэдээлэл солилцоно.   |
| | | 3.3.2 Захиргааны хэм хэмжээний актад дүн шинжилгээ хийж, зохих арга хэмжээг авах; | -Дүн шинжилгээ хийсэн байх - Зөрчилтэй захиргааны хэм хэмжээний актуудыг хүчингүй болгох, хуулиар эрх олгосон боловч зохих акт гаргаагүй бол боловсруулах, батлах үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байх; | Компанийн хэмжээнд мөрдөгдөж байгаа дүрэм, журмуудад дүн шинжилгээ хийж 11 журмыг шинээр болон шинэчлэн батлан өмнөх журмыг хүчингүй болгон үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. |
| | | 3.3.3. Компанийн ажилтнуудын ёс зүй, сахилга хариуцлагыг сайжруулах, хүнд суртал, чирэгдлийг арилгахад чиглэсэн сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах; | - Сургалт, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулсан байх; | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” аяны хүрээнд 2024 оны 04-р сарын 22 ны өдөр Хулгайлах, дээрэмдэх, залилах, олон нийтийн аюулгүй байдал, авлигал, ашиг сонирхлын эсрэг, мансууруулах сэтгэцэд нөлөөлөх бодисыг хууль бусаар ашиглах, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журам гэх зэрэг сэдвээр сургалтыг салбар нэгжүүдэд тус тус зохион байгуулсан. Сургалтыг харьяа дүүрэг, Аймгийн Аймгийн Засаг даргын тамгын газрын хууль эрх зүйн хэлтэс, Анхан болон давж заалдах шатны шүү, Прокурорын газар, Цагдаагийн газар% Хүүхэд гэр бүл хөгжил хамгааллын газар зэрэг газрын төлөөллүүд оролцсон сургалтыг тус тус явуулсан. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | Компанийн ажилтнуудын ёс зүй, сахилга хариуцлагыг сайжруулах, хүнд суртал, чирэгдлийг арилгахад чиглэсэн сургалтыг ЗААА-ны дарга Б.Гүрдорж, ХАБЭАИ/ДХА С.Зоригтбаатар нар 2024.09.27-ны өдөр салбарын Хурлын танхимд танилцуулж мэдээлэл хүргэсэн. Нийт 64 ажилтан хамрагдсан. Авлигын эсрэг хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийг сурталчлах, Авлигаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг тодорхойлох, хүнд суртлыг бууруулах чиглэлээр 2024 онд шинээр томилогдсон албан тушаалтнууд болон хөрөнгө орлогын мэдүүлэг гаргадаг албан тушаалтнуудад сургалтуудыг явуулсан. Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан сургалтад Zoom-ээр тухай бүр хамруулсан. Авлигын эсрэг хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийг сурталчлах, Эрх бүхий албан тушаалтнуудад АТГ-аас явуулсан сургалтад тогтмол хамрагдсан |

...o0o...